- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,986,826.4 мянган төгрөг болж 82,583.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 34,174.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 735 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 13 төрлийн хөрөнгийг 96,704.2 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн болон 748 дугаар тогтоолоор 434,975.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 213,511.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 790,732.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 350,639.6 мянган төгрөг, нийт 1,141,372.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 294,008.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,084,741.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 94,271.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 444,911.6 мянган төгрөгөөр, нийт 1,529,653.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,084,741.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 444,911.6 мянган төгрөг, нийт 1,529,653.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,438,661.6 мянган төгрөгийг зарцуулж, 90,991.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,438,661.6 мянган төгрөг буюу 94.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 79,817.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшууллыг 11,173.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	1,084,741.4	993,750.0	90,991.4	91.6
80101 – Үндсэн үйл ажиллагааны зардал	997,466.4	917,648.6	79,817.7	92.0
80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	27,059.8	15,886.2	11,173.6	58.7
81806 – Дотуур байрны үйлчилгээ	60,215.2	60,215.2	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	444,911.6	444,911.6	-	100.0
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	444,911.6	444,911.6	-	100.0
ДҮН	1,529,653.0	1,438,661.6	90,991.4	94.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын дотуур байрны түрээсийн 21,080.9 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2023 онд урсгал төсвийн хөрөнгөөр 9 нэр төрлийн хөрөнгө, үйлчилгээг худалдан авахаар 34,174.0 мянган төгрөг төлөвлөн, 3 аж ахуйн нэгж, 1 иргэнтэй гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад "Сэлэнгэ буман буудай" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 09 дүгээр сарын 06-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлыг биет бус хөрөнгөөр бүртгэсэн зөрчлийг арилгахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор М.Энхтуул гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,560,778.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,607.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус МСҮТ-ийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт **17,996.0** мянган төгрөгийн зөрчил илэрснээс илүү цагийн хөлсийг илүү олгосон 1 зөрчилд төлбөрийн акт, худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 1 зөрчилд албан шаардлага, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй 2 зөрчилд зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,825.4	1	3,825.4	100
Албан шаардлага	2	8,157.6	1	8,157.6	100
Зөвлөмж	2	6,013.0	1	6,013.0	100
Нийт дүн	5	17,996.0	5	17,996.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан нормативт зардлын зарцуулалтын тооцооллыг шалгах, үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм .

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **99,832.1** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Тайлант онд дахин үнэлсэн **96,704.2** мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бус дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 4.69-т “Дт Үндсэн хөрөнгө: Кт Тайлант хугацааны үр дүн “ гэж заасантай нийцээгүй байна.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд **3,127.9** мянган төгрөгийн хоолны зардлыг цалингийн зардалд ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”* гэж заасантай нийцээгүй байна.

Аудитаар нийт **12,817.5** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **219.5** мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, **5,323.0** мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, **7,275.0** мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт: Албан хаагчдын Улаанбаатар хот, аймаг сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **219.5** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага:

1. Цалингийн урьдчилгааны 1,741.5 мянган төгрөгийг давхардуулан тайлагнаж, НДШ, ХХОАТ-ыг тооцоолсноос шалтгаалан НДШ-д 417.9 мянган төгрөгийг, ХХОАТ-д 154.1 мянган төгрөгийг зэрэг нийт **572.0** мянган төгрөгийг илүү шилжүүлсэн боловч авлага үүсгэлгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*” 20 дугаар зүйлийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага хүргүүлэв.

2. Батлагдсан цалингийн зардлаас 2 албан хаагчид “Байгууллагын шилдэг ажилтан”-аар шалгарсан гэх үндэслэлээр шагналын зардалд 2,249.0 мянган төгрөг, буцалтгүй тусламжид 827.0 мянган төгрөг зэрэг нийт **3,076.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

3. 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор **1,675.0** мянган төгрөгийн 45 толгой мал тоологдсон атал санхүүгийн тайланд 3,690.0 мянган төгрөгийн 90 толгой мал тайлагнаж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй бөгөөд мал тооллогын үр дүн, дутагдсан малыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлж байх, мал тооллогын үр дүн, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Тус байгууллага нь оюутнуудад зориулан цахим сургалт хийх зорилгоор E-MIND онлайн сургалтын 1 жилийн эрхийг **7,275.0** мянган төгрөгөөр худалдан авсныг зардлаар бус биет бус хөрөнгөд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 4.66 дахь “*Биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, эзэмшигчдэдээ эрх, давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу тал олгодог хөрөнгийг биет бус хөрөнгө гэнэ.*” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж нь: Зардлыг биет бус хөрөнгөөр бүртгэсэн зөрчлийг арилгаж, 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгээгүй	1	96,704.2					1	96,704.2				
Санхүүгийн үр дүнгийн тайланд хоолны зардлыг цалингийн зардалд ангилал буруу бүртгэсэн	1	3,127.9					1	3,127.9				
Дүн	2	99,832.1					2	99,832.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож, олгосон	1	219.5	1	219.5								
Зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан	1	3,076.0			1	3,076.0						
НДШ, ХХОАТ-ын авлага үүсгэж, авлагыг шууд зардлаар тайлагнасан	1	572.0			1	572.0						
Жилийн эцэст малын дутагдал үүсгэж, үр дүнг шийдвэрлээгүй	1	1,675.0			1	1,675.0						
Зардлыг хөрөнгөд буруу бүртгэсэн	1	7,275.0					1	7,275.0				
Дүн	5	12,817.5	1	219.5	3	5,323.0	1	7,275.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим мэдээлэл											
Дүн											
Нийт дүн											-



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 12/ААБ60388
СГА-2024/230-НА-СГА-ТМЗ

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хавсралтад дурдсан албан хаагчдын Улаанбаатар хот, аймаг сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн 219.5 мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5: "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон 219.5 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загдгочоо, нягтлан бодогч Т.Түвшинжаргал нарт хариуцуулав.

018050029

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

М.ЭНХТУУЛ

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын
2024 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн
10/А.260.88 дугаар актын хавсралт

Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлт

/мянган төгрөгөөр/

№	Албан хаагчийн овог, нэр	Албан тушаал	Мөнгөн дүн
1	Б.Хишигжаргал	Захирал	69.0
2	Т.Түвшинжаргал	Нягтлан бодогч	46.0
3	Б.Бат-Эрдэнэ	Дотоод хяналт, статистик хариуцсан ахлах мэргэжилтэн	26.0
4	Г.Уугантуяа	Сургалтын менежер	38.5
5	М.Эрдэнэжаргал	Багш	20.0
6	Г.Отгонпүрэв	Үйлдвэр сургалт, нийгмийн түншлэл хариуцсан арга зүйч	20.0
		Нийт дүн	219.5



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 31/А.1860388
СЭА-2024/250-НА-СЭА-ТМЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн урьдчилгааны 1,741.5 мянган төгрөгийг давхардуулан тайлагнаж, НДШ, ХХОАТ-ыг тооцоолсноос шалтгаалан НДШ-д 417.9 мянган төгрөгийг, ХХОАТ-д 154.1 мянган төгрөгийг зэрэг нийт 572.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн боловч авлага үүсгэлгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас авлага үүсгэсэн, авлагыг бүртгэл тайланд тусгаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

018040091

2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загдгочоо, нягтлан бодогч Т.Түвшинжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

АУДИТОР



М.ЭНХТУУЛ





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 30/АБ60388
СЭА-2024/230-НА-СЭА-ТМЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан цалингийн зардлаас 2 албан хаагчид “Байгууллагын шилдэг ажилтан”-аар шалгарсан гэх үндэслэлээр шагналын зардалд 2,249.0 мянган төгрөг, буцалтгүй тусламжид 827.0 мянган төгрөг зэрэг нийт 3,076.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

018040094

2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загдгочоо, нягтлан бодогч Т.Түвшинжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

АУДИТОР



М.ЭНХТУУЛ





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 33/ААБ0388

Сүхбаатар

СВА-2024/250-НА-СГА ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 1,675.0 мянган төгрөгийн 45 толгой мал тоологдсон атал санхүүгийн тайланд 3,690.0 мянган төгрөгийн 90 толгой мал тайлагнаж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй бөгөөд мал тооллогын үр дүн, дутагдсан малыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана, 4.2.1.1: "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлж байх, мал тооллогын үр дүн, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

018040093

2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загдгочоо, нягтлан бодогч Т.Түвшинжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

АУДИТОР



М.ЭНХТУУЛ

